

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2019.11.07, №6 (122)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

WEEKLY



ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан

Эдийн засагч, нийтлэлч

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮҮРЭГ



БОЛОВСРОЛ

Б.Насанбаяр

Ph.D /Боловсрол судлал/

ТӨРИЙН ӨМЧИЙН ИХ СУРГУУЛИУДЫГ НЭГТГЭЖ ҮҮ?

IV НҮҮРТ

ДеФакто **ТОЙМ**

➤ **ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦТЭЙ
ХОЛБООТОЙ 2 АСУУДАЛ**

➤ **СЭТГҮҮЛЧДИЙГ ТАГНАЖ,
ЧАГНАСАН АСУУДАЛ**

➤ **Ц.САНДУЙ, А.ГАНБААТАР
НАРТ 4 ЖИЛИЙН ХОРИХ ЯЛ
ОНООЛОО**

VI НҮҮРТ



Өнгөрсөн 50 жилд монголын төр, засгийн удирдлагын үйл ажиллагааны арга барилд зарчмын өөрчлөлт гарсангүй. Харин гарсан гэж ярьдаг улс төрчид л олон боллоо. Яагаад гэвэл төр, засгийн удирдах албан тушаалд очсон бараг хүн бүр өөрийгөө хэмжээгүй эрхтэй хаан болгож, иргэддээ хамжлагын тариачин шиг хандаж, бүхнийг захиран шийдэх аргаар хандсан хэвээрээ байна. Нийгмийн үндэс суурь болох өмчийн харилцааг өөрчлөн, эдийн засгаа зах зээлийн замаар хөгжүүлэх хууль, журам гаргасан ч нийгмийн бусад харилцааг зохицуулахдаа төр засаг өөрийн дассан, социализмын хуучин арга барилаасаа агуулгын хувьд салж чадахгүй байна.

Үндэстний давуу талаа тодруулан хөгжүүлэхэд Засгийн газар хамгийн чухал үүрэг гүйцэтгэх тухай ойлголт үндэсгүй болохыг Харвардын их сургуулийн шинжээчид тогтоожээ. Төр, засаг өөрийгөө эдийн засгийн салбар бүрт туслагч, дэмжигч үүрэгтэй гэж үзэх нь тухайн салбарын компаниуд урт хугацаанд өрсөлдөх чадвараа хөгжүүлэхэд нь саад болж, улмаар эдийн засгийн тасралтгүй сайжрах боломжийг алдагдуулдаг байна. Манай улсад жишээ нь, өргөн хэрэглээний гол гол барааны үнийг өсгөхгүй байхын тулд тодорхой барааг (мах, шатахуун гэх мэт) бөөнөөр нь худалдан авч удтал хадгалж байгаад, нийлүүлэлт хомсодсон үед зах зээлд гаргаж, доогуур үнээр борлуулдаг. ▶▶

▶ Энэ “тусламжийн” бодит өртөг (хадгалалтын зардал, алдагдал, борлуулагчийн сонголт болон тээврийн зардал) борлуулж байгаа үнээсээ хамаагүй өндөр болдог. Энэ бол үнэндээ нийгмийн нэг хэсгийг нь нөгөө хэсгийнх нь мөнгөөр дэмжих гэсэн орлогыг дамжуулах улс төрийн бүтэлгүй үйл ажиллагааны нэг. Энэ “тусламжийг” улс орны хэмжээнд авч үзвэл материаллаг алдагдлаас гадна тэр салбарын компаниудын өрсөлдөх эрмэлзэл, хүсэл зоригийг мохоож, оронд нь зарим бизнес, улс төрчдийн харилцааг хэт ойртуулж, хээл хахуулийг хөхиүлэн дэмжиж байгаа учир нийгэмд материаллаг биш томоохон гарз учруулж байна. Тусламж зөвхөн тусламжийн хэрэгцээг өсгөхөд л тусалдаг. Харин эдийн засгийн өрсөлдөх чадварыг хөгжүүлэхэд төр, засгийн гүйцэтгэх хамгийн гол үүрэг бол шахагч, соригч байх явдал гэж шинжээчид үзэж байна.

Улс орон өрсөлдөх давуу талаа тодруулан хөгжүүлэхийн тулд Засгийн газар нь бизнесийн орчин нөхцлийг сайжруулахад анхаарахын зэрэгцээ бизнесийн өрсөлдөөнийг бүх талаар дэмжих шаардлагатай. Харин хөдлөшгүй ганц зарчим бол хүний аюулгүй байдал, байгаль орчинд нөлөөлөх стандартыг маш нарийн тогтоож, чанд мөрдүүлэх ёстой. Жишээ нь Испани улсад барилга байшин барихад тавих шаардлага өндөр, маш тодорхой байдаг бөгөөд төрийн холбогдох бүх институци тэдгээр стандартуудаа ягштал баримталдаг. Барилгын компаниуд өндөр шаардлагыг биелүүлж ашигтай ажиллахын тулд хамгийн сайн технологи нэвтрүүлж,


үргэлж шинийг санаачлан өрсөлдөж ажилладаг учир энэ улс дулаан, хүйтэн, дуу чимээ тусгаарлагч хана цонх, төлөвлөлт, загвараар хамгийн сайн байшин барилгатай хэмээн Европтоо алдаршжээ.

Засгийн газар бизнесийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэхийн тулд шаардлагатай дохиог цагт нь өгөх бас үүрэгтэй. Жишээ нь Японы Засгийн газар 70-аад онд Японы бараа хямдхан, тааруухан гэсэн имижийг өөрчлөх зорилгоор чанартай холбоотой бүх стандартаа сайжруулж, Демингийн гэх алдарт шагналыг бий болгосон нь компаниуд бизнесээ төлөвлөхөд нэн чухал дохио болжээ. Төгс чанарын баталгаа болсон энэ шагналыг авах нь компанийн нэр хүндийн хэрэг болсон учир 10-аадхан жилийн дараа Япон л гэвэл чанар хэмээн сонсогдох болж, удалгүй бараг бүх компани бүтээгдэхүүнээ экспортолж эхэлжээ.

Гэтэл манайд олон нийтийн зарим байгууллагууд хамгийн их татвар төлснөөр нь компаниудыг жагсааж (уг нь татвар төлсөн эсэх нь төрийн хэрэг баймаар), дээрээс нь таслан ангилж, шагнал гардуулахтай холбоотой зардлаа хэд нугалан өөрөөр нь төлүүлж “урамшуулдаг” гэрчилгээг эс тооцвол монголын төр энэ талаар ямар ч бодлогогүй бололтой. Зөвхөн татварын оролцоогоор хэмждэг тэр шагнал нь үйл ажиллагааны онцлогоосоо хамаарч тэртэй тэргүй онцгой татвар өгөх ёстой архи, тамхи, шатахуун борлуулдаг компаниудыг ялгаж салгадаггүй нь бүр хачирхалтай.

Компаниудын гол зорилго бол татвар төлөх биш, харин тухайн салбартаа өрсөлдөх чадвартай байж, бизнесийн цар хүрээгээ тэлэх, өөрийн бүтээмжээр ялгаран зах зээлд байр сууриа бэхжүүлж, өндөр ашиг олох явдал. Эдийн засгийн салбар дахь төр, засгийн гол үүрэг нь аж ахуйн байгууллага бүр хөдөлмөрийн бүтээмж, хөрөнгийн өгөөжөө нэмэгдүүлэхийн төлөө тасралтгүй хичээж, үргэлж шинийг санаачлах дотоод хэрэгцээг бий болгоход оршино. Төр засаг бизнесийн үйл ажиллагааг дэмжих, туслах биш, харин шахах, сорих үүрэгтэй.

ХӨДӨЛГҮҮРИЙН МӨНХИЙН ҮС



**TOTAL QUARTZ 9000
5W-40**



**ДОКТОР АВТО СҮЛЖЭЭ
ДЭЛГҮҮРИЙН БҮХ САЛБАРААР
ХУДАЛДААЛАГДАЖ ЭХЭЛЛЭЭ.**

Холбоо барих утас: 9411-7143, 9906-6402

 www.minesup.mn

 @TOTALMongolia

 fb.com/TOTALMongolia

 @TOTALMongolia

Албан Ёсны Дистрибьютор:

UP
MINES
www.minesup.mn



НИЙТЛЭЛ

Б.НАСАНБАЯР
Ph.D /Боловсрол судлал/

ТӨРИЙН ӨМЧИЙН ИХ СУРГУУЛИУДЫГ НЭГТГЭХ ҮҮ?

Монгол улсад дээд боловсрол судлал хөгжөөгүй, улс төрөөс бүрэн хараат, сургалтын төлбөрөөс бараг 100 хувь санхүүждэг тогтолцоо нь чанар түүнтэй холбогдох үр дүнг бүтээх боломжийг булаасаар өдийг хүрлээ.

Өнөөгийн УИХ, Засгийн газрын дээд боловсролын бодлогыг тодорхойлох эрх мэдэл бүхий хүмүүс төрийн өмчийн 8 их сургуулийг “хүчээр” нэгтгэх нь дээд боловсролын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэх арга зам, “мэргэн шийдэл” гэж тодорхойлоод, хүчээр нэгтгэсний үр дүнд дэлхийд тэргүүлэх их сургуулиудтай эн зэрэгцсэн судалгааны их сургуультай болно гэж мэдэгдэж байна.

2010 онд МУИС-тай Улаанбаатар их сургууль, Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийг нэгтгэсэн хэдий ч удаа дараа хэл ам, тэмцэл болсоор буцаад өрх тусгаарласан түүхтэй.

УЛС ТӨРИЙН “ХҮЧ ЧАДАЛ” БА ЧАНАРГҮЙДЛИЙН ТОЙРОГ...

Ардчилсан улс төрийн системтэй улс оронд бусдаас ялгарах бодлого, мөрийн хөтөлбөр дэвшүүлэн, сонгогчдын олонхын дэмжлэгийг авсан улс төрийн нам төрийн эрхийг барьж, “онцгой” мөрийн хөтөлбөрөө төрийн бодлого болгон хэрэгжүүлэхийг эрмэлзсээр ирсэн. Энэ эрмэлзэл нь дээд боловсролын бодлого эрх баригч нам, салбарын сайд солигдох бүрт өөрчлөгдөн хувирч, урт хугацааны, тууштай, тогтвортой бодлого үгүй болж, хөгжлийн залгамж чанар алдагдахад хүргэдэг. Энэ удаагийн төрийн өмчийн 8 их сургуулийг нэгтгэх шийдэл нь хэрэгжсэн тохиолдолд улс төрийн тоглоомын сонгодог жишээ болно.

Төрийн өмчийн их, дээд сургуулиудын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, захирлыг салбарын сайд томилж байгаа нь их, дээд сургуулийн удирдлага бүхэлдээ улс

төрөөс шууд хараат, улс төрийн нам, хүчний эрх ашиг, зорилгод захирагддаг байсныг эрс өөрчилсөн дээд боловсролын хуулийн нэмэлт өөрчлөлтийг 2016 оны 4 сард тухайн үеийн УИХ, Засгийн газрын шийдвэрээр хийсэн байдаг. Тус шийдэл нь удирдах зөвлөлд төрийн төлөөлөл 51-60 хувийг бүрдүүлдэг байсныг 30 хувь болгож; олон нийтийг төлөөлсөн хараат бус итгэмжлэгдсэн гишүүдээр 40 хувийг бүрдүүлэх, захирлыг удирдах зөвлөлөөс томилж байхаар заасан нь их, дээд сургуулийг улс төрийн ашиг сонирхлоос тусгаарлах, хөгжлийн тогтвортой тууштай бодлого баримтлах, баталгаа болохоор хуульчилсан юм. Хараат бус итгэмжлэгдсэн гишүүд улс төрийн албан тушаал хашдаггүй, эдийн засаг болоод оюуны хувьд тухайн сургуульд хөрөнгө оруулалт, дэмжлэг хийх чадвартай, хөгжлийн төлөө зүтгэх сонирхолтой, бизнес,

хууль, санхүү, эдийн засгийн өндөр боловсрол, туршлагатай бүхий л салбарын чадварлаг зүтгэлтнүүд 6 жилийн хугацаатай ажиллахаар тусгасан байсан.

Гэвч сонгуулийн үр дүнгээр бүрдсэн МАН-ын УИХ, Засгийн газар тус өөрчлөлтийг 2016 оны 11 сард яаран сандран буцаасан. Аливаа нэг улс төрийн бүлэглэл хяналтаа тогтоохын тулд боловсролын байгууллагыг үзэл суртлын индэр, “улаан булан” болгон хувиргаж зөвхөн өөрсдийн эрх ашиг, сонирхолд нийцсэн, өөрсөдтэйгээ үзэл бодол нэгтэй хүмүүсээр удирдуулахыг зорьдог жишгээр МАН-ын УИХ, Засгийн газар хөгжлийн шийдлээс ухарсан ч “төрийн өмчийн их сургуулиудыг нэгтгэн судалгааны их сургууль байгуулна” гэж үлгэр ярихын учир юу вэ?

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Өнөөгийн УИХ, Засгийн газрын төрийн өмчийн их сургуулийг нэгтгэх саналтай ижилхэн шийдлийг ОХУ-ын Засгийн газар тэргүүлэх их сургуулиуддаа зориулан 2005 онд Federal University program, 2006 онд Innovative University program, 2009 онд National Research University program, 2013 онд Russian Academic Excellence Project 5-100 гэсэн тусгай хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлжээ. Гэтэл “Холбооны их сургуулиудыг нийлүүлсний дараах

үр дүн өмнөхөөс алдагдсан, орон нутаг, бүс нутгийн шинжтэй байсан сургуулиуд глобал болж чадсангүй. Эдгээр их сургууль өөрчлөлтийг бүрэн хариуцаж хэрэгжүүлэхийн тулд түүний удирдлага болон төрийн зүгээс энэхүү шийдлийн глобал зорилго, тодорхой үр дүнг холбогдох талуудад таниулан, бүрэн дэмжлэг авах нөхцөл бүрдүүлэх шаардлагатай” гэсэн судлаачдын дүгнэлт гарсан байна. (Tatiana Jean, *IFRI* expert on Russian universities)

АНУ-ын 4000 гаруй дээд боловсролын байгууллагын 220, Их Британийн 300 дээд сургуулийн 25, БНХАУ 3000 гаруй сургуулийнхаа 100 орчмыг дэлхийн түвшний судалгааны их сургууль болгон хөгжүүлэх зорилттой ажиллаж байна.

2013 онд Судалгааны их сургуулийг хөгжүүлэх талаар гарсан “*Хэфэйн тунхаглал*”- д “судалгааны их сургуулийг үр ашигтай институци болгоход чиглэгдсэн үйл ажиллагааг бүх талаар дэмжсэн бодлого, эрх зүйн орчин бүрдсэнээр их сургуулийн өрсөлдөх чадварыг сайжруулан олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх боломж нээгдэнэ. Ийм орчин бүрдээгүй нөхцөлд судалгааны их сургуулийн өрсөлдөх давуу талыг бий болгох, төлөвшин хөгжүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх боломжгүй” гэж үзжээ. Хэфэйн

тунхаглалд орчин үеийн судалгаанд суурилсан их сургуулийн үндсэн шинжийг дараах байдлаар тодорхойлжээ.

1. Нээлттэй засаглалын тогтолцоотой, олон улсын хэмжээнд чадварлаг мэргэжилтнийг татах чадвартай шилдэг хүний нөөцийг бүрдүүлсэн байх;
2. Өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинжлэх ухааны үндэслэлтэй эрхэм зорилгоо тодорхойлж, стратегийн төлөвлөгөө хэрэгжүүлдэг, судалгаа, сургалтын тэргүүлэх чиглэлээ бие даан тодорхойлох эрхтэй байх;
3. Судалгааны ёс зүй, түүнтэй холбоотой хэм хэмжээний стандартыг мөрддөг, эрдмийн эрх чөлөөг хариуцлагатайгаар хэрэгжүүлдэг байх;
4. Судлаачдыг тасралтгүй бэлтгэж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлдэг байх;
5. Тэргүүлэх салбарт бакалаврын болон ахисан түвшний сургалтаар үндэсний болон олон улсын түвшинд инновацийг бий болгох, нэвтрүүлэх чадамжийг бүрдүүлсэн байх.

БОДЛОГЫН ЗАЛГАМЖ ЧАНАР...

Төрийн өмчийн 8 их сургуулийг нэгтгэнэ гэсэн муйхар шийдлээс илүү дээд боловсролын байгууллагын бие даасан байдал, засаглалыг бэхжүүлэх эрх зүйн орчин, эрдэм шинжилгээ судалгаа, сургалт, хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд 2012-2016 оноос эхлэн хэрэгжүүлсэн ажлыг үргэлжлүүлэн хөгжүүлэх нь “судалгааны их сургууль”-ийн ирээдүйн хөгжилд тустай.

- Тухайлбал дэлхийн шилдэг их сургуулийн жагсаалтыг тэргүүлдэг MIT буюу Массачусетсийн технологийн институттэй Монгол улсын Засгийн газар 2015 онд гэрээ байгуулан “MIT-Монгол улс санаачлага” төслийг ШУТИС дээр хэрэгжүүлж эхэлсэн. Энэ төслийн хүрээнд MIT-ШУТИС-ийн багш оюутнууд хамтран хот судлал ба төлөвлөлт, байгаль орчин ба эрчим хүч, био-технологи, геологи зэрэг судалгааны чиглэлүүдээр өргөн хэмжээний хамтарсан судалгааны хөтөлбөр хэрэгжүүлсэн байх учиртай.
- 2014 онд эхлүүлсэн “Инженер, технологийн дээд боловсрол” буюу 1000 инженер бэлтгэх төслийн хүрээнд 1005 оюутан багш коосэн, бакалавр, магистр, доктор, зэргийн бус сургалтанд хамрагдаж, 20 чиглэлээр судалгаа хийж үр дүнг үйлдвэрлэлд шилжүүлэх учиртай. Мөн тус төслийн хүрээнд МУИС, ШУТИС-ийн

инженерийн хөтөлбөр нь Японы шилдэг их сургуулиудын түвшинд хүрч хүлээн зөвшөөрөгдөх үйл явц, үр дүн нь судалгааны их сургуулийн суурийг тавих боломжтой.

- Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар барилга, тоног төхөөрөмж барьж байгуулах, хүний нөөцийг чадавхжуулах АШУУИС-ийн “Их сургуулийн эмнэлэг”-ийн иж бүрэн төслийн хүрээнд эрүүл мэндийн салбарын судалгаа жинхэнэ утгаараа хөгжих боломжтой.
- Германы Засгийн газрын дэмжлэгтэй байгуулагдсан Монголдоо төдийгүй зүүн хойд Азийн бүс нутагтаа олон улсад хүлээн зөвшөөрөгдөх инженер бэлтгэх зорилготой “Монгол Германы хамтарсан Технологийн сургууль”-ийн (МГТИС) сургалт, судалгааны хөгжил нь уул уурхай, ашигт малтмалын салбарт томоохон хувь нэмэр оруулна.

Төр барьж буй нам, сайд хэн байхаас үл хамааран МУИС, ШУТИС, МУБИС, АШУУИС, МГТИС зэрэг сургуулиуд дээр хэрэгжиж буй сургалт, судалгааны Олон улсын жишигт баримжаалсан ажлын залгамж чанарыг хадгалах нь судалгааны их сургуулийг хөгжүүлэх үйлсэд оруулах том гавьяа.



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.11.03-ны дугаар
Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

Зочин тоймч: Эрх зүйч Х.Номингэрэл |

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦТЭЙ ХОЛБООТОЙ 2 АСУУДАЛ

Энэ долоо хоногт Үндсэн хуулийн цэцтэй холбоотой 2 үйл явдал боллоо. 10-р сарын 30-ны өдөр Үндсэн хуулийн цэц их суудлын хуралдаанаараа Ашигт малтмалын тухай хуулийн тодорхой заалтуудыг хүчингүй болгох шийдвэр гаргалаа. Мөн цэцийн дарга Д.Одбаяр Инчеон дээр саатуулагдлаа.



Д.ОДБАЯР

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

Үндсэн хуулийн цэц эдийн засгийн бодлогын асуудлаар шийдвэр гаргах эрхтэй юу. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг болиулж байгаа шийдвэр нь үндэслэлтэй юу?

МУ-ын Үндсэн хуульд зааснаар Үндсэн хуулийн цэц төрийн албан тушаалтны үйл ажиллагаа, хуулиудыг үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянах үүрэгтэй байгууллага. 10-р сарын 30-ны өдрийн шийдвэрээр Ашигт малтмалын тухай хуулиас хүчингүй болгосон 7 заалтын шалтгааныг харвал нэлээн ойлгомжгүй байдалтай байна.

Тухайлбал 47.1 -ийг харвал

47 дугаар зүйл. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

47.1. Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд болон Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.

/Энэ хэсэгт 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсгийг 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

/Энэ хэсгийн "Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө." гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон./

Энэ заалтаас “болон Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банкинд алт тушаасан этгээд” гэсэн үгнүүд л үлдсэн байгаа бөгөөд энэ этгээд яг яах нь ойлгомжгүй. Энэ бол техникийн хувьд. Харин агуулгын хувьд үндсэндээ ашигт малтмалын роялтиг өнөөдрийн байдлаар хүчингүй боллоо гэж ойлгоход болохоор байна. Ямар ч шийдвэрүүд эдийн засгийн үр дагавартай байж болно. Гэхдээ үүнийг Үндсэн хуулийн дагуу байгаа

эсэхийг харахын тулд Цэцийн шийдвэрийн Үндсэн хуулиас ишлэсэн заалтуудыг онцгойлон харах ёстой. Цэцээс Үндсэн хуулийн доорх 2 заалтыг зөрчсөн гэж үзсэн.

Тавдугаар зүйлийн 4. Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.

Арван есдүгээр зүйлийн 1. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.

Дээрх 2 заалтаас дүгнэхэд энэ заалтууд ашигт малтмал ашигласны төлбөртэй шууд уялдахад хол байгаа юм. Цэц дүгнэлтэндээ ашигт малтмал ашигласны төлбөрийг давхардуулсан нь эдийн засагт сөрөг нөлөөтэй гээд эдийн засгийн дүгнэлт хийсэн байна лээ. Уг нь эдийн засагтай холбоотой асуудал дээр Цэц болгоомжтой хандах ёстой гэсэн зарчим байдаг.

Цэцийн шийдвэрээр үүссэн нөхцөл байдлыг залруулж ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг сэргээн тогтоохоор Сангийн яамнаас хуулийн төсөл боловсруулан нэн яаралтай горимоор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна гэж мэдээлсэн. Боломж нь хэр вэ?

Хуулийн төсөл боловсруулаад дахиж батлуулах боломж мэдээж байгаа. Гэхдээ 2020 оны төсвөө бид 11-р сарын 15-ны дотор батлах ёстой. Сангийн сайдын дурдсан шиг их хэмжээний мөнгө төсвөөс дутвал төсвийн алдагдал өндөр гарна гэсэн үг шүү дээ.



Khurelbaatar Chimed
@KhurelbaatarCh

Ноцтой мэдээ... Үндсэн хуулийн цэцийн гишүүд ээ. Та нарын өнөөдрийн шийдвэрээр ашигт малтмалын нөөц ашигласны татвар үгүй болж төсвийн орлого жилд 1.3 их наяд төгрөгөөр буурахад хүрч байна. Товчхондоо Ашигт малтмал ард түмний өмч биш компаниудын өмч болж байна. Арай ч дээ!!!

7:00 PM · Oct 30, 2019 · Twitter for iPhone

577 Retweets 502 Likes

Үндсэн хуулийн цэцийн дарга Инчеоны онгоцны буудал дээр саатуулагдсан мэдээ гарч байна. Ямар асуудал болов. Ийм хэрэгт Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн дарга холбогдсоноор ямар хариуцлага хүлээх вэ?

Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр ажлын байрны бэлгийн дарамт үзүүлсэн гэдэг асуудалтай

холбогдож байгаа нь өөрөө маш ёс зүйгүй үйлдэл мөн.

Төрийн албаны тухай хуулийн 37-р зүйлд ажлын байрны бэлгийн дарамтыг хориглосон. Хориглосон зүйл заалтуудыг хийсэн бол сахилгын арга хэмжээ авна гэсэн зүйл заалт ч байгаа. Хэмжээнээс нь хамаараад ажлаас халах хүртэл арга хэмжээ авна гэсэн байгаа. Гэхдээ Цэцийн дарга гэдэг энэ өндөр албан тушаалтанд хэн хариуцлага тооцох нь ойлгомжгүй байна л даа. Ихэвчлэн сахилгын хариуцлагыг байгууллага өөрөө тооцдог. Гэтэл байгууллагын дарга нь ийм асуудалд холбогдчихсон явж байна. Цэцийн гишүүдийн хувьд ёс зүйн дүрэм байдаггүй юм байна лээ. Тэгэхээр яаж шийдэгдэх нь тодорхойгүй ч, хуульд заагаагүй гээд хариуцлага хүлээхгүй байна гэж байхгүй. Учир нь ямар ч төрийн өндөр албан тушаалтнууд хууль ёс, ардчилалд итгэх итгэлийг хадгалахын тулд өөрсдөө үлгэрлэн харуулж ёс зүйн хариуцлага хүлээх ёстой гэж харж байна.

Монголд ажлын байрны бэлгийн дарамт ямар түвшинд байна вэ?

Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг маш олон ТББ ажиллаж байгаа. Монголын эмэгтэйчүүдийн сангийн хийсэн судалгаагаар 5 хүн тутмын 1 нь ажлын байрны бэлгийн дарамтад өртсөн гэж байдаг. Ажлын байрны бэлгийн дарамт гэдэг нь харахаас л эхлэж байгаа юм л даа, биед нь хүрэх, тэврэх, дүрс зураг үзүүлэх, бэлгийн сэдэлтэй тоглоом шоглоом хийх зэрэг олон үйлдэл ордог. Эдгээрийг ялгах гол зүйл нь түүнд өртөж байгаа хүнд хэр зэрэг таатай болон таагүй сэтгэгдэл төрүүлж байгаагаас л хамаардаг. Тухайн орчинд бэлгийн сэдэлтэй үг, үйлдэл үзүүлж тавгүй тухгүй болгож л байгаа бол энэ нь ажлын байрны бэлгийн дарамтад тооцогдоно. Энэ үзэгдэл монголд харьцангуй элбэг ч хууль зүйн хувьд шийдвэрлэх тогтолцоо нь сул хэвээр байгаа.

Энэ асуудал 2011 онд Жендерийн эрх тэгш байдлын тухай хуульд анх орсон ба үүнийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд ажил олгогч гол үүрэгтэй гэж заасан. Гэвч үүнийг хөдөлмөрийн аюулгүй байдлын нэг хэсэг гэж ойлгож, сургалт хийдэг, дотоод журамдаа оруулдаг тогтолцоо сул байгаа. Хөдөлмөрийн хуульд энэ асуудал орчихсон явж байгаа ч УИХ дээр хэлэлцэгдэхгүй удаж байна. Хариуцлагын тогтолцооны хувьд Эрүүгийн хуульд байж байгаад одоо байхгүй болсон ч, Зөрчлийн тухай хуулийн нэмэлт төсөлд орчихсон явж байгаа. Энэ асуудлыг таслахад нэг хүнийг шийтгээд өнгөрөх хангалтгүй. Ажлын байрны бэлгийн дарамт гэдэг асуудлын гол хариуцлага хүлээгч нь ажил олгогч байх ёстой. Учир нь энэ бол илүү соёлын буюу бүтцийн шинжтэй өөрчлөлт байх ёстой юм.

СЭТГҮҮЛЧДИЙГ ТАГНАЖ, ЧАГНАСАН АСУУДАЛ

Сэтгүүлчдийг тагнаж чагнасан гэх асуудал өнөөдөр яригдаж байгаа асуудал биш л дээ. 2018 оны 4-р сард нэр бүхий 8-9 сэтгүүлчийг тагнаж, чагнасан гэсэн асуудал Хууль зүйн сайдтай холбогдож яригдаж эхэлсэн. Гэтэл энэ долоо хоногт болсон Сэтгүүл зүйн ёс зүйн форум дээр энэ асуудал дахин сөхөгдлөө.

Энэ хэрэгт Хууль зүйн сайд Ц.Нямдорж холбогдсон ба тухайн үед няцаасан мэдэгдэл хийж байсан. Гэтэл энэ асуудлыг Х.Нямбаатар гишүүн дахин гаргаж ирлээ. Нэгэнт эргэлзээ үүссэн тохиолдолд хэвлэл мэдээллийнхэнд ил тод мэдээлэл өгөөд, эргэлзээг арилгах нь чухал. Одоо яагаад энэ асуудлыг ил болгож болохгүй гэж.

Мөн энэ асуудлын талаар Цагдаагийн байгууллагаас хариу мэдэгдэл гаргасан ба түүндээ “хэрвээ тагнуулж, чагнуулсан сэтгүүлч, редакц байгаа бол гомдлоо эрх бүхий байгууллагад гаргах нь нээлттэй” гэж бичсэн байгаа юм. Аль сэтгүүлч, хэнд, хэзээ тагнагдсанаа мэдэхгүй байж яаж гомдол гаргах вэ?

Сэтгүүлчдийг олон нийтэд мэдээлэл хүргэх үндсэн чиг үүрэгт нь холбож тагнаж байгаа бол хэвлэлийн эрх чөлөөг хөндсөн асуудал. Хэвлэл бол мэдээллийг олж, түгээх замаар ардчиллыг ажиллуулдаг том хэрэгсэл.

Ц.САНДУЙ, А.ГАНБААТАР НАРТ 4 ЖИЛИЙН ХОРИХ ЯЛ ОНООЛОО

Прокуророос “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулсан” гэж яллах дүгнэлт үйлдсэн, 60 тэрбумын гэх хэргийн шүүх хурал энэ долоо хоногт боллоо. Гэтэл анхан шатны шүүх Ц.Сандуй, А.Ганбаатар нарт сонгуулийг будлиантуулсан гэдгээр зүйлчлэн 4 жилийн ял өглөө.

Энэ шүүхийн шийдвэрийн хувьд 2 асуудал байна. Эхнийх нь, прокурорын ялласан зүйл ангийн хүрээнд л шүүх шийдвэр гаргана, хэрвээ тэр зүйл ангийг хангахгүй байгаа бол хэрэгсэхгүй л болгох ёстой байдаг шүү дээ. Удаах нь, хэрвээ хөнгөрүүлэх нөхцөл байдал байвал шүүх хөнгөрүүлж болно гэсэн байдаг. Гэхдээ тухайн зүйл анги дотроо хөнгөрүүлдэг. Гэтэл энэ тохиолдолд шал өөр зүйл анги руу оруулсныгаа хөнгөрүүлж байна гэж тайлбарлаад байна л даа.

Прокурорын ялласан зүйл ангийн дагуу нотлох баримт, өмгөөлөл, яллагаа шүүхийн танхимд хийгдэж байхад шүүхээс шал өөр зүйл ангиар ял өгч байгаа нь шүүхийн ялласан зүйл ангийн дагуу ямар ч өмгөөлөл, яллагаа явагдаагүй гэсэн үг болж байна. Хэрвээ прокуророос сонгуулийг будлиантуулсан гэсэн зүйл ангиар яллаж шүүхэд шилжүүлсэн бол шүүхийн танхимд тэр зүйл ангийн дагуу яллах, өмгөөлөх процесс явагдана шүү дээ. Тэгэхээр будлиантай л болчихож байгаа юм л даа. Үүнийг эрүүгийн хууль зөрчсөн



Ц.САНДУЙ

А.ГАНБААТАР

үйл явдал гэж үзэх үндэслэлтэй. Бид ардчилал, хууль ёсонд итгэх итгэлийг хууль ёсны дагуу процедурыг явуулж байж л хадгална шүү дээ. Хууль дээдлэх зарчмын (Rule of law) хүрээнд ямар ч байгууллага ажиллах ёстой.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.*

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976 94109342
🌐 www.defacto.mn
www.jargaldefacto.com